



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ХОРИХ 415-Р АНГИ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

Төв аймгийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан
Утас: 70272582
И-мэйл: jargalsaihan_tuv@yahoo.com
Факс: 01-272-22582

Аудитын менежер: О.Амаржаргал
Утас: 70273465
И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Аудитор: Ц.Саранчимэг
Утас: 70273204
И-мэйл: tsaranchimeg@yahoo.com

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн Аудитын газрын хаяг:
Төв аймаг Зуунмод сум 6-р баг
Төрийн байгууллагуудын 2-р ордон
Цахим хуудас: tuv@audit.gov.mn

2017 оны 02 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 415-р ангийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ТӨВ-2017/18/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 415-р ангийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 415-р ангийн 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дүгээр сарын 25-ныг хүртэл хугацаанд хийхээр төлөвлөн Төв аймгийн Аудитын газрын санхүүгийн аудитын багийн гишүүн ахлах аудитор Ц.Саранчимэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 415-р ангийн 2016 оны төсвийн санхүүгийн тайланг 2017 оны 01 дугаар сарын 25-нд Төв аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Төв аймгийн Аудитын газар аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дүгээр сарын 22-нд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 415-р ангийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1-д Энэ хуулийн зорилт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, иргэний болон эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа /цаашид "шийдвэр гүйцэтгэх ажиллагаа буюу тогтоол

гүйцэтгэх ажиллагаа" гэх/-ны эрх зүйн үндэс, журмыг тогтооход оршино" гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Тус байгууллагын эрхэм зорилго нь "Шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэж, цагдан хорих, баривчлах болон хорих ял эдлүүлэх үйл ажиллагааг олон улсын жишгийн түвшинд хуулийн хүрээнд зохион байгуулах, эд хөрөнгийн холбогдолтой шийдвэр бүрийн биелэлтийг хангах, үйлчлүүлэгч, хэрэглэгчид шуурхай үйлчлэхэд оршино." гэж тодорхойлон, 2016 онд ШШГЕГазар " Дэвшил, чанар, ёс зүй" гэсэн зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 9.1-д Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага улсын төсвөөс санхүүжинэ." гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38 –д "төсвийн шууд захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 415-р ангийн дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг ШШГЕГазраас баталж Төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 415-р ангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 55 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 8 асуудал эрсдэл өндөр, 4 асуудал эрсдэл дунд, 0 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 36 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 8 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн программаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн

санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 415-р анги 2016 онд 1591495.1 мянган төгрөгийн санхүүжилт, 6034.6 мянган төгрөгийн хөрөнгийн санхүүжилт, 3192.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт, туслах үйл ажиллагааны орлого 85995.5 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 118754.5 мянган төгрөгийн орлого олжээ. Үүнээс урсгал зардалд 1870947.5 мянган төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 1081.7 мянган төгрөгийн хэмнэлт гарсан байна. Энэ нь туслах үйл ажиллагааны орлого давуулан биелүүлсэнтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үндсэн бус үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогоор 95500.0 мянган төгрөг батлагдснаас гүйцэтгэлээр 112410.5 мянган төгрөгийн орлого төвлөрч 16910.5 мянган төгрөгөөр орлого давуулан биелүүлсэн байна.

Шилэн дансны мэдээлэл:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 415-р анги нь 2016 оны 10 сард хийгдсэн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгах нийцлийн аудитаар мэдээлбэл зохих 24 мэдээлэлийг бүрэн оруулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын 9, нарийвчилсан 1, нийт 10 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагавар Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 415-р ангийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 1000.0 мянган төгрөгөөс дээш дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт зардлын 97.4 хувийг эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний 26848.2 мянган төгрөгийн алдаа илэрсэн байна. Үүнд:

1. ШТН ТӨААТҮГазраас авах 2014 онд үүссэн 25900.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-д санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, 6.4.8-д төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дансанд бүртгэлтэй авлагыг барагдуулах талаар тодорхой үр дүнд хүрсэн ажил зохион байгуулах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2. Цахилгааны зардлын нэхэмжлэл, төлөлтийг тооцоо нийлсэн акттай тулган шалгахад 947.5 мянган төгрөгийн дутуу төлөлтийг тайлагнаагүй байгаа нь НББТХ -ийн 20.2.6-эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Цахилгааны тооцоог дамжуулан хэрэглүүлэгч компанитай болон харилцагч байгууллагатай тооцоо хийж байх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

3. Батлагдсан төсвийн хэмнэлт болох 25108.3 мянган төгрөгийг шилжүүлэн жилийн хэрэглээний нүүрсний авлага үүсгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-д санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, 6.4.8-д төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

4. 1545.0 мянган төгрөгийн нэр данс буруу орсон орлогыг дансны харьцаа буруу хийсэн нь НББ-ийн тухай хуулийн 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад нэр данс зөрүүтэй орлогын бүртгэлийг залруулсан.

5. Бараа материалын тусгай зориулалтын материалаас үндсэн хөрөнгийн батлах хамгаалах тоног төхөөрмжийн дансанд шилжүүлсэн нь НББ-ийн тухай хуулийн 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад бараа материалаас 4550.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгө рүү шилжүүлэн бүртгэж залруулсан.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад 6095.0 мянган төгрөгийн алдаа залруулагдсан болно. Материаллаг бус 25108.3 мянган төгрөгийн алдаа залруулагдаагүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй байж болох гэрээт ажилын гүйцэтгэл, цахилгааны зарцуулалт, хүнсний үлдэгдэлд тооллого хийх завсрын аудитаар нөхөн шалгахгаар тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 415-р ангийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 58051.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс материаллаг 6095.0 мянган төгрөгийн алдааг залруулж, материаллаг бус 25108.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 415-р ангийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд аудит хийж 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн хариуг албан бичгээр Төв аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:
Зөрчилгүй санал дүгнэлт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 415-р ангийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

**ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР**

**Л.ЖАРГАЛСАЙХАН
О.АМАРЖАРГАЛ**

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ц.САРАНЧИМЭГ

Огноо: 2017.02.22